



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 08-ны өдөр

Дугаар А/04

Эрдэнэт

“Тусгаарлан ажиглах байрны бэлэн
байдлыг хангах тухай”

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 209 дүгээр тогтоол, Шадар сайдын 2020 оны “Түр журам батлах тухай” 155 дугаар тушаалын 10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгаарлан ажиглах байрны бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын чиг үүргийг нэгдүгээр, тусгаарлан ажиглах байрны урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйтгэл хийх байгууллагын хуваарийг хоёрдугаар, тусгаарлан ажиглах байрнаас ялгарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тусгаарлан ажиглах байрыг бэлтгэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /А.Баярхүү/, Эмнэлгийн тусламж үйлчилгээ /Б.Уртнасан/ нарт үүрэг болгосугай.
3. Тусгаарлан ажиллах байранд нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үзүүлэх багийг шинэчлэн томилж, үүрэгжүүлэн ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал/Б.Батсүх/-д даалгасугай
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт үнэлгээний баг, ХШҮДАХМэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын чиг үүрэг

Ахлагч :

Б.Билгүүнээ - Эрүүл мэндийн газрын халдвар судлаач

Гишүүд :

Б.Эрдэнэбаяр - ОБГ-ын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч

Л.Номин - МХГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Б.Билэгсайхан - ЦГ-ын Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч

Ажлын чиг үүрэг :

1. Ажлын хэсэг нь тусгаарлан ажиглах байраар сонгогдсон байранд тухай бүр хяналт хийж дүгнэлтийг АОК-ийн Шуурхай шатбын дарга, менежерт хүргүүлэх
2. Тусгаарлан ажиглах байруудад үүрэг гүйцэтгэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний болон хоол үйлдвэрлэлийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх дэглэмийн сургалтад хамруулсан, давтан сургасан байдалд хяналт хийх
3. Үүрэг гүйцэтгэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудын ажилтан албан хаагчдыг шаардлагатай хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангуулах, дархлаа дэмжих, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих .
4. Тусгаарлан ажиглах байрны хяналтын камерын бичлэгт явцын хяналт хийж иргэдийн дэг журам, сахилга хариуцлагын талаарх мэдээллийг АОК-ийн Шуурхай шатбын дарга, менежерт хүргүүлэх
5. Тусгаарлан ажиглах байрны урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйтгэлд хяналт тавих
6. Тусгаарлан ажиглах байрнаас ялгарах хог хаягдлын ангилал, түр цэг, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд хяналт тавих

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 01 дүгээр сарын
08-ний өдрийн /08/ дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ТУСГААРЛАН АЖИГЛАХ БАЙРАНД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН ГОЛОМТЫН
ЭЦСИЙН ХАЛДВАРГУЙТГЭЛ ХИЙХ ХУВААРЬ

№	Ажиглалтын байр	Хунтхайрхан ХХК	Цасны хачир ХХК	Сайнтүшиг ХХК	Хөхбилэгт ХХК	Цэцэншунхлай ХХК
1	Эрдэнэт зочид буудал					
2	Сэлэнгэ зочид буудал					
3	Голд зочид буудал					
4	Тесеро зочид буудал					
5	Элит зочид буудал					
6	Молор зочид буудал					
7	Цэцэг зочид буудал					
8	Дээдэс зочид буудал					
9	Наадам төв зочид буудал					

